

Булган аймаг Бүрэгхангай сумын нутаг дахь
"ТУУЛЫН БАРУУН ДЭНЖ-ХОТУ" алтны шороон ордын
2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН
(Тусгай зөвшөөрлийн дугаар MV-017238)
(ААН-ын регистерийн дугаар: 2763788)

Хянасан:

Булган аймгийн БОАЖГ-ийн УУ-н мэргэжилтэн..... / Ц.Ганчимэг/

Биелэлтийг тайлагнасан:

"ХОТУ" ХХК-ны захирал / Х.Олонбаяр /

"ХОТУ" ХХК-ны байгаль орчны мэргэжилтэн..... / Ш.Түвшинбат /

2022 он

Гарчиг

Гарчиг.....	1
1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.1 Төсөл хэрэгжүүлж буй газрын байршил , харьяалал.....	4
1.2 Төслийн үргэлжлэх хугацаа	5
1.3 Ордын геологийн тогтоц	5
1.4 “Туулын баруун дэнж-ХОТУ уурхайн техник эдийн засгийн үндэслэл	6
1.5 Уулын ажлын гүйцэтгэл /2022.10.28/.....	7
1.6 Уурхайн ажиллах горим ба угаан баяжуулах цехийн технологи	9
1.7 ХОТУ ХХКомпанийн байгаль орчны үнэлгээ холбогдох бичиг баримтууд.....	12
2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	13
2.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт.....	13
2.2 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	15
2.3 Хөрс, ургамалан бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	19
3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	23
4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	30
5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	35
6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	35
7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	35
8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	40
9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	44
10.ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	46
11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	49
12. ДҮГНЭЛТ	51

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1 MV-017238 ТАЛБАЙН СОЛБИЦОЛ	5
Хүснэгт 2 БҮТЭЭГДЭХҮҮН ГАРГАЛТ	7
Хүснэгт 3 Баяжуулах цехийн ажиллах горим	9
Хүснэгт 4. ОХШ дээж авсан цэгийн координат.....	45
Хүснэгт 5. БОМТөлөвлөгөөний зардал-2022 он	50

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байр зүйн зураг	4
Зураг 2. Олборлолт явуулсан талбай.....	8
Зураг 3 Усан сан болон олборлолт явуулж буй талбай.....	10
Зураг 4. Баяжуулах технологийн тоног төхөөрөмжийн холболтын схем.....	11
Зураг 5. Уурхайн зам дээр усалгаа хийж буй байдал	14
Зураг 6. Эвдэрсэн зам засаж буй байдал , зам түрсэн байдал.....	15
Зураг 7. Усны тоолуур суурилуулан лац тавьж байна Ундны усаа Шижир алт суурингаас зөөврөөр авч буй байдал.....	17
Зураг 8. Цэнгэг нуур болон дахин ашиглах тунаах нуур	17
Зураг 9. Цэнгэг нуур болон Дахин ашиглах тунаах нуур,	18
Зураг 10. Уурхайд нэмэлтээр тэмдэг тэмдэглэгээ самбар хийж байршуулав	21
Зураг 11. Шимт хөрс хуулж авч буй байдал , 2022 оны биологи хийх талбайд шимт хөрсний овоолго хийж тараав	21
Зураг 12. Олон салаа зам гаргахаас сэргийлж тэмдэг тэмдэглээ байршуулав	21
Зураг 13. Тос масло ангилан хадгалах цэг.....	22
Зураг 14. Түр хогийн цэгээс тухай бүр хогоо зайлуулж байна.....	22
Зураг 15. Дотоод овоолгоор , гадаад овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийж буй байдал ..	24
Зураг 16. Биологийн нөхөн сэргээлтэнд талбай түрж тэгшилж байгаа нь	25
Зураг 17. Шимт хөрсөөр хучиж буй байдал	25
Зураг 18. Шимт хөрсөө тарааж буй байдал	25
Зураг 19. 2020-2021 онд тарьсан модоо услаж буй байдал	26
Зураг 20. Хамгаалалтын хашаа хийж буй байдал	26
Зураг 21. Олон наст согоовор , царгас тарьж буй байдал	27
Зураг 22. Олон наст согоовор, царгас услаж буй байдал	28
Зураг 23. Олон наст согоовор, царгас ургаж буй байдал	28
Зураг 24. Олон наст согоовор , царгас ургаж буй байдал	29
Зураг 25. Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд орон нутгийн талбайд хийсэн техникийн нөхөн сэргээлт /	
Зураг 26. Орон нутгийн талбайд техникийн нөхөн сэргээлт хийхийн өмнө, дараа.....	33
Зураг 27. Зөвшөөрөл авч ойд унаж өгөршсөн модыг түүж цэвэрлэв	32
Зураг 28. Ан амьтан, байгаль хамгаалах сургалт хийж буй нь	32
Зураг 29. Дүйцүүлэн хамгаалах чиглэлэрэ Номт булгийн эх тохижуулав	33
Зураг 30. Гал унтраах хэрэгсэл хангэж , аянга зайлуулагч суурилуулав.....	336
Зураг 31. Сургалт хийж буй байдал	37


Зураг 32. Хотхоноо газар хөдлөлийг тооцоолон байгуулсан.....	38
Зураг 33. Өдөр тутамын зааварчилгаа өгч халуун шалгаж буй нь.....	38
Зураг 34. Сургалт хийж буй байдал	38
Зураг 35. Тусгаарлах байр	388
Зураг 36. Тусгаарлах байрнаас гарахад ажиллагсадаас түргэвчилсэн шинжилгээ авч буй	38
Зураг 37. Ээлж солилцох үед техникт ариутгал хийж буй нь.....	39
Зураг 38. Ахуйн хогийг түр хадгалах цэгт байршуулан Хайлааст багийн хогийн цэгт хаядаг. 430	
Зураг 39. Ашигласан тос масло УБ хот руу Монголын хог хаягдал дахин боловсруулах үндэсний холбоонд тушаав	431
Зураг 40 Тамхи татах цэг , нүхэн жорлон.....	48
Зураг 41. Их цэвэрлэгээ хийж карьерийн хог түүв	482
Зураг 42 Тусгаарлах байр гаргаж шаардлагатай эм, ариутгах бодис бусад нэг удаагийн хувцас хэрэглэлээр хангав	47
Зураг 43. Анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулав.....	47

ХАВСРАЛТ МАТЕРИАЛИУД

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төсөл хэрэгжүүлж буй газрын байршил , харьяалал

- Төслийн нэр:** “Туулын баруун дэнж-ХОТУ” алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл
- Төсөл хэрэгжүүлэгч:** Хувийн хөрөнгө оруулалттай “ХОТУ” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011055022, Регистрийн дугаар: 2763788, Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар : MV-017238
- Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:** Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, С.Чоймболын гудамж, 15172-28А тоот, утас1:310888, утас2: 99115268
- Төслийн байршил:** Төслийн талбай нь Булган аймгийн Бүрэгхангай сумын Дэрст багийн нутагт харьяалагддаг бөгөөд Улаанбаатар хотоос баруун хойш 240 км, Дархан хотоос баруун урагш 240 км, Булган аймгийн Бүрэгхангай сумын төвөөс зүүн зүгт 54 км-т Төв аймгийн Заамар сумтай хил залгаа нутагт оршдог.



Зураг 1. Төслийн талбайн байр зүйн зураг

Хүснэгт 1 MV-017238 ТАЛБАЙН СОЛБИЦОЛ

Цэгийн дугаар	Солбицол		Талбайн хэмжээ (га)
1	48° 17' 35.82"	104°23'11.93"	316.67 га
2	48° 17' 2.82"	104°23'11.93"	
3	48° 17' 2.82"	104°22'51.92"	
4	48° 17'7.82"	104°22'51.93"	
5	48° 17' 7.82"	104°22'8.93"	
6	48° 18' 10.81"	104°22'8.94"	
7	48° 18' 10.81"	104°22'53.94"	
8	48° 18' 30.81"	104°22'53.94"	
9	48° 18' 30.81"	104°23'21.93"	
10	48° 17' 35.82"	104°23'21.93"	

1.2 Төслийн үргэлжлэх хугацаа

Төсөл эхэлсэн огноо: Хоту ХХК нь 2003 онд байгуулагдан 2006 оноос уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байна. Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт Туулын баруун дэнж нэртэй газарт орших 316.67 гектар талбай бүхий MV-017238 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2012 оны 12-р сарын 14-ны өдрийн Кадастарын хэлтэсийн даргын №114 тоот шийдвэрээр 2012 оны 12-р сарын 19-ны өдрөөс 30 жилийн хугацаатай олгосон.

Төсөл хэрэгжих хугацаа: Ашигт малтмалын газрын даргын тушаалаар Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших MV-017238 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Туулын баруун дэнж-ХОТУ” алтны шороон ордыг ил аргаах ашиглах техник эдийн засгийн үндэслэлийг хүлээн авсан.

1.3 Ордын геологийн тогтоц

“Туулын баруун дэнж-ХОТУ” алтны шороон ордод 2010-2011 онуудад гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайланг 2012 оны 07 сарын 05-ны өдөр Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн ба АМГ-ын даргын 2012 оны 07 сарын 19-ны өдрийн 474 дугаар тоот тушаалаар ордын нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэсэн байна.

Тухайн ордыг бүрдүүлэгч хурдасны ерөнхий зүсэлтийг хайгуулын ажлын явцад цооногийн бичиглэлээр хийсэн бөгөөд дээрээс доош үзүүлвэл:

1. Бор хүрэн өнгийн шавранцар найрлагатай шимт хөрсний үе. Үеийн зузаан 0,2-0,8м
2. Жижиг хэмхдэс хайрга ховроор агуулсан /20% хүртэл/ бор саарал, бор шаргал цайвардуу саарал өнгийн шавранцрын үе. Үеийн зузаан 0.8-6.4м.
3. Бор шаргал, улбар шаргал өнгийн шавранцарын үе
4. Бор саарал өнгийн элсэнцэр, шавранцараар чигжигдсэн харьцангуй сайн мөлгөржсөн жижиг ба нарийн ширхэгтэй хайрга хайрганцарын мэшил үе. Ховроор дунд хэмжээтэй хэмхдэс, хайрга агуулна. үеийн зузаан 1,2-4,0м
5. Улбардуу саарал, улаан шаргал, ягаавтар өнгийн шаврын үе. Ховроор жижиг ба нарийн ширхэгтэй дундаас сайн мөлгөржилттэй хайрга, сайрга агуулна. үеийн зузаан 0,6-2,8м
6. Бор саарал өнгөтэй том ба дунд хэмжээтэй хэмхдэс хайрга 30-40% агуулсан нарийн хайранцар, элсэнцэрийн үе. Алтны ядуу агуулгатай. үеийн зузаан 1,2-4,4м
7. Сайн мөлгөржсөн жижиг дунд хэмжээтэй хайрга 20-30% орчим, нарийн хайрга сайрга 10% агуулсан бор шаргалдуу (ховроор улбардуу) өнгийн шавранцарын (элсэрхэг материал ихтэй) үе . Энэ үе нь алтны үйлдвэрлэлийн агуулга өгдөг. үеийн зузаан 0,4-2,8м
8. Ногоовтор өнгөтэй зарим тохиолдолд улаан хүрэн өнгийн үндсэн чулуулгийн өгөршлөөр үүссэн шаварлаг найрлагатай элювийн гаралтай хурдас. өгөршилд орж бутрамтгай болсон мөлгөржөөгүй хэмхдэс материал 30-40% орчим агуулсан байх ба доошлох тусам хэмхдэс материалын эзлэх хувь ихсэж аажмаар үндсэн чулуулагт шилжинэ. Дээд хэсэгтээ нэлээд өндөр алтны агуулгатай. Сэвсгэр хурдасны нийт зузаан 29,0 м байна.

Насны хувьд алт агуулагч хурдас нь дээд дөрөвдөгчийн настай $/Q_3^{2-3} - Q_3^4/$ Туул голын хөндийн элс, хайрга бүхий голын гаралтай хурдас, хучаас хурдас нь Туул голын татам, пролюв, делювийн саарал өнгийн элсэнцэр, шавранцараас тогтох орчин үеийн настай хурдас болох нь харагдаж байна.

1.4 “Туулын баруун дэнж-ХОТУ уурхайн техник эдийн засгийн үндэслэл

Уул уурхайн яам, Ашигт малтмалын газрын Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлөөр 2014 оны 5-р сарын 08-ны өдөр ХОТУ ХХК-ны захиалгаар Уул уурхайн зураг төслийн “Майн СИО” ХХК –ны боловсруулсан . Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших Туулын баруун дэнж-Хоту алтны шороон ордыг ил аргаар ашиглах техник йэдийн засгийн үндэслэлийг хэлэлцэн № 14-08-02 тоот дүгнэлтийг гаргасан. Энэхүү дүгнэлтийг үндэслэн Ашигт малтмалын газрын даргын тушаалаар Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших MV-017238 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Туулын баруун дэнж-ХОТУ” алтны шороон ордыг ил аргаах ашиглах техник эдийн засгийн үндэслэлийг хүлээн авсан.

Мөн 2020 оны 06-р сарын 30-ны өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал , Газрийн тосны газрын Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлөөр Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших MV-017238 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Туулын баруун дэнж-ХОТУ” алтны шороон ордыг ил аргаах ашиглах техник эдийн засгийн үндэслэлийн **тодотголыг** хэлэлцэн № Т/20-08-09 тоот дүгнэлт гаргасан. Тус № Т/20-08-09 тоот дүгнэлтийг үндэслэн


Ашигт малтмал, Газрийн тосны газрын даргын 2020 оны 09-р сарын 16-ны өдрийн № Т/173 тоот тушаалаар хүлээн авсан.

1.5 Уулын ажлын гүйцэтгэл

2022 онд В-2, В-10 дугаар блокуудад олборлолтын ажил явагдах төлөвлөгөөний дагуу В-2, В-10 блокод ашиглалт явуулсан. 2022 оны төлөвлөгөөгөөр 197,2 мян.м3 хөрс хуулж, 66.81 мян.м3 элс угааж химийн цэврээр 21,83 кг металл авахаар төлөвлөснөөс 2022 оны 10-р сарын 28-ны байдлаар 52,2 мян.м3 хөрс хуулж, 12.3 мян.м3 элс угааж химийн цэврээр 6,86 кг металл олборлосон.

Хүснэгт 2 БҮТЭЭГДЭХҮҮН ГАРГАЛТ

№	Ажлын төрөл	Хэмжих нэгж	2022 оны бүтээгдэхүүн гаргалт сар тус бүрээр							нийт
			5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	
1	Элс олборлолт	м ³	2508	1610	2008	3187	2568	419		12300
2	Элсэн дэх алтны агуулга	мг/м ³	0.257	0,256	0,258	0,258	0,258	0,263		
3	Элсэн дэх алтны хэмжээ /	кг	1.399	0.896	1.120	1.777	1.432	0.236		6.86
4	Баяжуулах элс	м ³	2508	1610	2008	3187	2568	419		12300
5	Металл авалт	%	92,5	92,5	92,5	92,5	92,5	92,5		92,5
6	Алт /химийн цэврээр/	кг	1.399	0.896	1.120	1.777	1.432	0.236		6.86



Зураг 2. 2022 онд 1,8 га Биологийн нөхөн сэргээлт явуулсан талбай

1.6 Уурхайн ажиллах горим ба угаан баяжуулах цехийн технологи

Тус ордын элсийг скрубберт баяжуулбал тохиромжтой. Ордын элс нь хялбар угаагдах шинж чанартай боловч скруббер нь элсийг сайн угаадаг юм.

ХҮСНЭГТ 3 БАЯЖУУЛАХ ЦЕХИЙН АЖИЛЛАХ ГОРИМ

Баяжуулалтын хүчин чадал		
2022 оны нийт хүчин чадал	мян.м ³ /жил	29,100
Баяжуулалтын ажиллах горим		
Жилд ажиллах хоног	хоног	120
Бүтээлтэй ажиллах хоног	хоног	90
Техникийн үзлэг, угаалга хийх хоног	хоног	49
Хоногт ажиллах цаг/эхний жил/	цаг	17
Хоногт ажиллах ээлж	ээлж	2
Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	10
Баяжуулалтын ашиглалт		
Ашиглалтын коэффициент	-	0.94
Баяжуулалтын технологи		
Технологи	Гравитацийн арга /ЗЧШ-3 Скруббер, /	

Ил уурхайгаас ирэх алт агуулсан -100 мм ширхэглэлтэй элсийг скрубберт сайтар угааж жижиг оврын бутар ашиглан баяжуулж авна. **Бэлтгэл үйл ажиллагаа.** Ордын элс нь хялбар угаагдах шинж чанартай боловч сайтар угааж, задлах нь металл авалтыг бууруулахгүй сайн талтай. Тиймээс уг ордын элсийг скруббер ашиглаж угаана.. Ил уурхайгаас ирэх -100 мм-ийн ширхэглэлтэй анхдагч элсийг скрубберт оруулж сайтар угааж задалсны дараа 20 мм-ийн диаметртэй тороор шигшигдэж +20-100 мм ангиллын бүтээгдэхүүн нь галийн овоолгод хаягдана. -20+0 ангиллын бүтээгдэхүүн нь хоригт цоргод тэжээгдэнэ. **Баяжуулах үйл ажиллагаа.** -20+0 мм-ийн ширхэглэлтэй элсийг жижиг оврын угаах төхөөрөмж буй бутар ашиглаж ялган авна. Дараа нь лотки ашиглан баяжуулж шлихтэй алтыг ялган авна.

Хаягдлын сан. Скрубберээс гарсан +20-100 мм ширхэглэлтэй бүтээгдэхүүн нь галийн овоолгод хаягдана. Хоригт цоргоноос гарсан хаягдал нь эфелийн овоолгод хаягдана. хоригт. Хаягдлын санд хуримтлагдсан технологийн ус нь 2 тунаах нуураар дамжин цэвэршээд эргээд технологид хэрэглэнэ.


Технологийн усны хэрэгцээ: Байгаль орчныг хамгаалах, цэвэр усны нөөцийг хэмнэх зорилгоор үйлдвэрийн технологийн усан хангамжинд хэрэглэгдэх усыг хуримтлуулж, цэвэршүүлэх замаар эргүүлэн ашигласан. Технологийн усыг Туул голоос гадаргын ус ашигласан. Ажиллагсадын ундны усыг Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн суурингийн худгаас худалдан авч хэрэглэсэн. Технологийн усыг битүү эргэлтийн системээр ашиглахаар хаягдлын болоод цэвэр усны санг байгуулсан. Алт олборлож байгаа үйлдвэрүүдийн туршлага, түүнчлэн алтны шороон ордын элс баяжуулах технологийн тооцоог баримталж шаардагдах усны 20%-ийг цэвэр усаар

сэлбэх ба 80%-ийг технологийн эргэлтийн усаар хангасан. Технологийн зориулалтын усыг голоос татахдаа цахилгаан соронзон тоолуур суурилуулан ашиглаж сумын байгаль орчны хяналтын байцаагч болон Туул голын сав газраас хяналт тавин ажиллаж байна.

Далангийн хийц: Далангуудыг ус шүүрэлтийг багасгах зорилгоор шавар материалаар хийсэн хамгаалалтын бүрхүүл хийх ба ашигласан карьерийн орон зайд нууруудыг үүсгэх ба усан сангийн усны түвшинг 5.0 м байхаар усан санг байгуулав. Усан сангийн урт 50 метр ба өргөн 40 метр дунджаар 10000 м³ байна. Эргэлтийн 1 , тунаах 1 нуур тус тус байгуулсан.



Зураг 3 Усан сан болон олборлолт явуулж буй талбай



Зураг 4. Баяжуулах технологийн тоног төхөөрөмжийн холболтын схем

УУРХАЙН ЦАХИЛГААН ХАНГАМЖ: Алтны уурхайн цахилгаан хангамжийн асуудлыг дизель генератор ашиглаж шийдсэн. Уурхайн цахилгааны гол хэрэглэгч нь ус дамжуулах насос, угаах төхөөрөмж, засварын цех, уурхайн тосгон болон бусад жижиг хэрэглэгчид байна.

Ил уурхайн уулын ажил явагдах нийт ажлын талбай, үйлдвэр, цехийн байр, ажиллаж байгаа машин техникийн ойр орчим, ажилчдын байнга явах зам зэрэг талбайнуудыг гэрэлтүүлэхдээ прожектор ашиглан гэрэлтүүлсэн.

6. Уурхайн зам

Хотхоноос уурхайн талбай хүртэл 1.120 м үндсэн зам байна.

Уурхайн карьераас угаах төхөөрөмж хүртэл 400м, шимт хөрсний овоолго хүртэл 500м туслах замыг тус тус засаж сайжруулсан замтай. Мөн ордоос элс угаах талбай хүртэл дунджаар 500м туслах замуудыг засаж түүнийг ашигласан. Салхи ихтэй тоосжилттой өдрүүдэд замын тоосжилт дарах зорилгоор усалгаа хийж байв.

1.7 ХОТУ ХХКомпанийн байгаль орчны үнэлгээ холбогдох бичиг баримтууд

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийж 2017 -12-04 өдөр БОАЖЯам дүгнэлт гаргасан
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг Хос санаа ХХК боловсруулан 2018 онд БОАЖЯам баталсан.
- Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт Туулын баруун дэнж нэртэй газарт орших 316.67 гектар талбай бүхий MV-017238 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2012 оны 12-р сарын 14-ны өдрийн Кадастарын хэлтэсийн даргын №114 тоот шийдвэрээр 2012 оны 12-р сарын 19-ны өдрөөс 30 жилийн хугацаатай олгосон
- Газар ашиглалтын гэрчилгээг Булган аймгийн Бүрэгхангай сумын Засаг даргын 2018 оны 9-р сарын 07-ны өдрийн А/129 тоот шийдвэрээр 316,67 га газрыг 5 жилийн хугацаатай Сөөгийн дэнж-д уул уурхайн зориулалтаар олгосон.


2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

БОМТөлөвлөгөөнд агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахаар 6-н төрлийн үйл ажиллагаа төлөвлөснийг бүрэн хэрэгжүүлсэнийг хүснэгтэнд тайлбарлан харуулав.

№	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Биелэлт
1	Уурхайн карьер, овоолго, зам, талбайн усалгааны хэмжээ, норм, горимыг сар, улирлаар оновчтой тогтоох,	Уурхайн карьерыг уулын ажлын төлөвлөгөөний дагуу нээж, овоолгыг салхин доор байрлуулан уурхайн талбайд хүчтэй салхи шуурганы үед тоосжилт бага байхаар зохион байгуулсан. Мөн дулааны улиралд зам, талбайн усалгааны хэмжээ, норм, горимыг сар, улирлаар оновчтой тогтоосон. Усан сангийн далан өндөрлөгөө хийхдээ борооны дараа хөрс чийгтэй үед тоосжилт үүсгэхгүйгээр зохион байгуулсан.
2	Ажлын байрны агаарын чанарыг сайжруулах, тоосжилтыг бууруулах арга хэмжээ тогтмол авч усалгаа хийж байх;	Дулааны улиралд тогтмолоор хүйтэн тоосжилт ихтэй үед дулаан өдрийг сонгон уурхайн карьерын дотоод зам талбайг өдөрт 2-3 удаа нийт 111 удаа 555 м.куб усаар усалж усалгаа хийсэн бүртгэлээ тогтмол хөтөлсөн. Хавсаргав.
3	Уурхайн ухалт, ачилт буулгалтын цагийг хоногийн салхины горимтой уялдуулан зохион байгуулах	Хүчтэй салхитай үед ачилт буулгалтыг багасгаж , зарим үед ажилаа зогсоох арга хэмжээ авч байв.
4	Хүнд механизмын хөдөлгүүрийн тохиргоо, үйлчилгээг тогтмолжуулах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах;	Суудлын автомашин, бага оврын ачааны болон самосвалиудад 5000км, 8000км, 10000км тутамд, экскаватор, ковш, бульдозерт 250, 500, 750, 1000, 2000 мот/цаг тутамд тос солих болон агаар шүүгч болон бусад шаардлагатай үйлчилгээнүүдийг хийдэг бөгөөд дотооддоо улирлын болон улсын жил тутмын үзлэг зэргийг тогтмол хийж гүйцэтгэж байна.

№	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Биелэлт
5	Уурхайн карьер доторх болон түүнээс гарч буй замуудад хайрга чулуу дэвсэх, замыг хусаж байх	Уурхайн замд хайрга чулуу дэвсэж замын хайрган хучилт хийсэн. Мөн эвдэрсэн замаас үүсэх тоосжилтыг багасгахаар замаа тогтол засаж байв. Үүнээс гадна хурдны хязгаар тогтоон 5км/ц , тоосжилт үүсэхээс сэргийлж байв.
6	Тоосноос эрүүл мэндээ хамгаалах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах,	Тоосжилтоос сэргийлж ажилтан бүр нэг бүрийн хамгаалах хэрэгсэл өмсөхөөс гадна хошуувч авч хангаж байна.



Зураг 5. Уурхайн зам дээр усалгаа хийж буй байдал



Зураг 6. Эвдэрсэн зам засаж буй байдал , зам түрсэн байдал

2.2 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Компани бүх үйл ажиллагаандаа усыг зохистой ашиглах, усыг дахин ашиглах, мөн үйл ажиллагаа явуулж буй байгаль дахь усны нөөц, чанарыг хэвээр хадгалахыг зорин ажилладаг. Уурхай технологийн зориулалттай усан хангамжаа Туул голоос авдаг. Унд ахуйн усаа өөрийн худаггүй тул Төв аймгийн Заамар сумын Шижир алт тосгоны унд ахуйн худгаас зөөврөөр авч хэрэглдэг. Гадаргын болон гүний усанд хамгаалалтын бүс тогтоож хамгаалалтын бүсэд мөрдөх журмыг чанд сахин ажиллах /сэргийлэх / ,Ахуйн шингэн болон хатуу хог хагдлын менежментийг хэрэгжүүлж ахуйн хатуу хаягдлаа ялган хаях /сэргийлэх / зорилгоор төлөвлөсөн дараах ажлуудыг бүрэн хийж гүйцэтгэснийг хүснэгтээр харуулав.

ХОТУ ХХК-ны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан -2022 он


№	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Биелэлт
1	Ахуйн болон ногоон байгууламж, тоосжилт дарах ус хэрэглээний хэмжээг нарийвчлан тооцож, усыг дахин хэрэглэх, хэмнэлттэй зарцуулах техник технологи судлах, ашиглах	үйл ажиллагаандаа усны дахин ашиглалтыг хамгийн багадаа 80% байлгахаар зорьж байгаа бөгөөд уурхайн нийт усны хэрэгцээг багасгах, эргүүлэн ашиглах усны хэмжээг нэмэгдүүлэх тулд ус ашиглалт болон усны дахин ашиглалтад тогтмол хяналт тавин ажиллаж байна. Зам усалгааг эргэлтийн нууранд тунгаасан уснаас хэрэглэж байна
2	Усны хэмжээ, чанарыг хянах, заагдсан цэгүүдээс шинжилгээ өгөх	Булган аймгийн Ус цаг уур орчины хяналт шинжилгээний итгэмжлэгдсэн лаборторитой гэрээ байгуулан жилд 2 удаа Уурхайн нуурын усан сангаас 2022-05-21-нд , 2022-09-23-нд тус тус шинжилгээ өгч 1548400 төгрөгний зардал гарсан. Координат болон шинжилгээний хариуг хавсаргасан.
3	Ус ашиглах дүгнэлт, гэрээг холбогдох орон нутгийн болон бусад холбогдох байгууллагатай хийж баталгаажуулах, төлбөрийг цаг тухай бүр төсвийн дансанд оруулах	Ус ашиглах дүгнэлтийг 2022-04-22 өдөр “Монгол-Ус” ТӨҮГаар тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөөн дээр үндэслэн ус ашиглах хэмжээг зориулалт тус бүрээр тооцоолон ус ашиглах дүгнэлтийг гаргуулан ажиллаж байна Туул голын сав газрын захиргаатай 2022-05-13 өдөр ус ашиглах гэрээ байгуулж Туул голоос авч буй технологийн усандаа 150 мм диаметртэй стандарт хэмжил зүйн газраар баталгаажуулсан цахилгаан соронзон тоолуур суурилуулан Бүрэгхангай сумын Байгаль орчны байцаагч Ж.Батжүгдэрээр лац тавиулан баталгаажуулж сар бүр тогтмол Бүрэгхангай сумын БО улсын байцаагч хяналт тавин ажилласан. 2022 оны 10-р сарын 28-ны байдлаар 5234,5 мянган төгрөний усны төлбөрийг бүрэн төлсөн.
4	Шатах, тослох материалын хаягдал, асгаралт гаргахгүй байх арга хэмжээ авах, төлөвлөлт боловсруулах	Шатах, тослох материалын хаягдал, асгаралт гаргахгүй байхаар засварын талбай байгуулсан, тос маслын хаягдлыг ангилан хадгалж Улаанбаатар дахь хаягдал тос масло дахин боловсруулах үйлдвэрт 800 л хаягдал тос масло тушаасан. Мөн карьерт гэнэт машин эвдэрбэл хөрсөнд тос масло нэвчилтээс хамгаалах материал олгож бүртгэл хөтөлж арга хэмжээ авсан
5	Бороо цас үерийн ус цуглуулах сан байгуулах, тоосжилт дарах зорилгоор хэрэглэх, үерээс хамгаалах далан байгуулах	Мөн үерийн ус борооны ус хуримтлуулахаар усан сан руу шуудуу ховил гаргаснаас урсан ирж хуримтлагдаж байв. Мөн үерээс хамгаалах далан байгуулсан.



Зураг 7. Усны тоолуур суурилуулан лац тавьж байна



Ундны усаа Шижир алт суурингаас зөөвөрөөр авч буй байдал



Зураг 8. Дахин ашиглах тунаах нуур, дахин ашиглах цэнгэг нуур



Зураг 9. Дахин ашиглах тунаах нуур, дахин ашиглах цэнгэг нуур

2.3 Хөрс, ургамалан бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Газар, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх болон бууруулахын тулд газрын эвдрэлийг хянах, шимт болон шимэрхэг хөрсний хамгааллын талаар хэрэгжүүлэх дараах ажлуудыг бүрэн хийж гүйцэтгэснийг хүснэгтэр харуулав.

№	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Биелэлт
1	Ил уурхай, овоолго байгуулах талбайн үржил шимт хөрсийг хуулж, 2 м-ээс өндөргүй овоолон хадгалах	Ил уурхайн шинээр олборлолтонд өртөх газрын шимт хөрсийг 0,2-0,3 м зузаантайгаар хуулж аваад тусгайлан 2 м-ээс өндөргүй овоолон хадгалсан. Зарим шимт хөрсийг 2022 онд биологийн нөхөн сэргээлт хийх төлбөйд шууд тарахаар байдлаар тараан овоолго үүсгэн хэрэглэсэн. Зөвхөн уулын ажилд заагдсанаас бусад газар хөндөхгүй байхаар зохион байгуулж хяналт тавьж хөрс ургамалан бүрхэвчээ хамгаалсан. Ургамлан бүрхэвчээ хамгаалах зорилгоор гадаад овоолго хийхгүй урьд ухсан ухаш нүх рүү дотоод овоолгоор дүүргэлт хийж сэргийлэн ажилласан.
2	Уурхайн дотоод гадаад тээвэрлэлтийн замыг хайрган хучилттай болгох	Уурхайн дотоод гадаад тээвэрлэлтийн замыг хайрган хучилттай болгосон
3	Тогтсон маршрутын дагуу тээвэрлэлт хийх	Тогтсон маршрутын дагуу тээвэрлэлт хийж зөвшөөрөөгүй замаар зорчихгүй байхаар уулын ажлыг зохион байгуулсан.
4	Замыг тэмдэгжүүлж, салаа зам гаргахаас сэргийлсэн ухуулах самбар хийж байрлуулах,	олон салаа зам гаргахгүй байхаар зохион байгуулж замыг тэмдэгжүүлж, салаа зам гаргахаас сэргийлсэн, ухуулах самбар байрлуулсан
5	Олон салаа зам гарахаас сэргийлж тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах	Олон салаа зам гарахаас сэргийлж тэмдэг, тэмдэглэгээ байрлуулсан. Мөн зөвхөн зориулалтын замаар зорчуулсан.
6	Шатах, тослох материал, ажилласан тосны хаягдлыг зориулалтын саванд хадгалах, орчинд асгарч алдагдахаас сэргийлэх,	Шатах, тослох материал, ажилласан тосны хаягдлыг зориулалтын саванд хадгалаж, орчинд асгарч алдагдахаас сэргийлэн Улаанбаатар дахь Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоонд 800 л тушааж хүлээлгэн өгөв.

№	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Биелэлт
7	ШТМ, агуулах болон засварын төвийн талбайг хатуу хучилттай болгож газрын гадарга, хөрс бохирдохоос сэргийлэх	ШТМ, агуулах болон засварын төвийн талбайг хатуу хучилттай болгосон, карьерт засвар хийхэд дэвсэх материал олгож газрын гадарга, хөрс бохирдохоос сэргийлсэн
8	Хог хаягдлыг тухай бүрт нь ангилан зайлуулах арга хэмжээ авах	Хог хаягдлыг тухай бүрт нь ангилан түр хадгалах цэгт байршуулан Төв аймгийн Заамар сумын Шижир алт тосгоны хогийн нэгдсэн цэгт асгасан.



Зураг 10. Уурхайд нэмэлтээр тэмдэг тэмдэглэгээ самбар хийж байршуулав



Зураг 11. Шимт хөрс хуулж авч буй байдал , 2022 оны биологи хийх талбайд шимт хөрсний овоолго хийж тараав



Зураг 12. Олон салаа зам гаргахаас сэргийлж тэмдэг тэмдэглээ байршуулав



Зураг 13. Тос масло ангилан хадгалах цэг



Зураг 14. Түр хогийн цэгээс тухай бүр хогоо зайлуулж байна

3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 онд уулын ажлын төлөвлөгөөний дагуу уулын ажилд хөндөгдсөн талбайгаас 3.1 га газарт техникийн нөхөн сэргээлт хийж шимт хөрсний овоолгыг тусад нь үүсгэж, 1,8 га газарт биологийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөнөөс 3,1 га газарт техникийн нөхөн сэргээлт 1,8 га газарт биологийн нөхөн сэргээлт хийсэн. Уурхайн үйл ажиллагааны эхэлсэн үеэс үйл ажиллагааны явцад хөндөгдөж буй газрыг цаг тухай бүрд нь нөхөн сэргээж, явцын нөхөн сэргээлтийг хариуцлагатайгаар хийж ирсэн. Нөхөн сэргээлтийн ажлыг Монгол улсын стандарт, журмын дагууд техникийн болон биологийн үе шаттайгаар гүйцэтгэж байна. Биологийн нөхөн сэргээлтийг хийхдээ зөвхөн тухайн бүс нутгийн экосистемийг бүрдүүлэгч байгалийн ургамлын үр олон наст ургамал царгас согооворыг үрээр тарьж ургуулсан. Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн талбайг хэмжээг маркшейдерийн хөндлөнгийн мэргэжлийн байгууллага Гранд инженеринг ХХК-аар хэмжилт хийлгэн зургийг хавсаргасан.


Нөхөн сэргээлтийн биелэлтийг хүснэгтээр харуулбал:

№	Нөхөн сэргээлтийн үе шат	Нөхөн сэргээлт хийсэн аргачлал	Гүйцэтгэл / га /	Биелэлт
1	Техникийн нөхөн сэргээлт	Техникийн нөхөн сэргээлт Гадаад овоолгоор	0,4 га	В13 ,В14, В15 блок дээр Гадаад овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийсэн
2	Техникийн нөхөн сэргээлт	Техникийн нөхөн сэргээлт Дотоод овоолгоор	3,1 га	Урьд жилийн болон энэ жилийн олборлолтонд өртсөн 12-18 метр гүн карьерийн ухаш нүхийг стандартын дагуу дотоод овоолгоор дүүргэлт хийн хэлбэршүүлж, тэгшлэн техникийн нөхөн сэргээлт хийгдсэн,
3	Техникийн нөхөн сэргээлт	Шимт хөрсний дэвсэх	0,2 га	Техникийн нөхөн сэргээлтээр талбайг хэлбэршүүлж, тэгшлэсэний дараа томоохон чулууг түүж дараа нь шимт хөрсийг 15-25 см дэвсэж хучсан
4	Биологийн нөхөн сэргээлт	Биологийн нөхөн сэргээлт	1,8	Биологийн нөхөн сэргээлт хийхэд зориулж бэлдсэн шимт хөрсөөр хучиж бэлдсэн 1,8 га газрыг бүрэн хашаажуулсан ба уг тайлбайн 0,9 га-д согоовор , 0,9 га талбайд царгас олон наст ургамлын үрийг суулгаж услан бүрэн ургуулсан.

Техникийн нөхөн сэргээлт /2022он/

1	454158.935	5348097.850	48 17 03.91885908	104 22 55.43685707
2	454176.019	5348267.823	48 17 09.42812429	104 22 56.19991564
3	454170.031	5348465.347	48 17 15.82364768	104 22 55.83218800
4	454258.445	5348467.128	48 17 15.90435566	104 23 00.12207171
5	454256.533	5348202.510	48 17 07.33384079	104 23 00.13244563
6	454241.287	5348100.764	48 17 04.03468836	104 22 59.43227681

Техникийн нөхөн сэргээлт-3.1 га




2022 онд нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ	5,5 га	
---	--------	--



Зураг 15. Дотоод овоолгоор , гадаад овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийж буй байдал



Зураг 16. Биологийн нөхөн сэргээлтанд талбай түрж тэгшилж байгаа нь



Зураг 17. Шимт хөрсөөр хучиж буй байдал




Зураг 18. Шимт хөрсөө тарааж буй байдал



Зураг 19. 2020-2021 оны тарьсан модоо услаж буй байдал



Зураг 20. Хамгаалалтын хашаа хийж буй байдал



**Биологийн нөхөн сэргээлт хийх талбай
/2022он/-1.8га**

1	454405.2442	5348730.1140	48 17 24.46	104 23 07.14
2	454330.4391	5348777.1370	48 17 25.96	104 23 03.50
3	454366.7291	5348947.3790	48 17 31.49	104 23 05.19
4	454440.3100	5348947.2640	48 17 31.50	104 23 08.76
5	454450.3100	5348927.2640	48 17 30.86	104 23 09.25
6	454450.3100	5348867.2640	48 17 28.91	104 23 09.28



Зураг 21. Олон наст согоовор, царгас , мөчрөөр тарьц суулгаж тарьж буй байдал



Зураг 22. Олон наст согоовор , царгас услаж буй байдал



Зураг 23. Олон наст согоовор , царгас ургаж буй байдал



Зураг 24. Улиас ,бургасны мөчрөөр үрсэлгээ хийж тарьсан модны байдал


4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Ашигт малтмалын ашиглалтын нөлөөлөлд өртөж буй биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлага бий болсон тул биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээлт хийх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

№	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Биелэлт
1	Орон нутгийн захиргаатай хамтран ажиллаж MV-017238 лицензийн талбайн орчимд 1 га газарт ухаш нүх, эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлт хийх	2022 онд MV-017238 лицензийн талбайн гадна 1 га газарт нинжа нарын сүйтгэсэн ухаш нүх, эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлт хийж хэлбэржүүлж тэгшилж орон нутгийн захиргаанд хүлээлгэн өгсөн.
2	Хууль бус ан агнуураас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	Нийт ажиллагсадад хууль бус ангаас сэргийлэх сургалт зохион байгуулсан ба уурхайн талбайн орчимд хууль бус ан хийхээс сэргийлж хяналт тавьж ажилласан
3	Төслийн талбайн ойр орчим болон 1-р багийн нутагт орших “Номт” гэдэг газрын амьтад ундаалдаг булаг усны эх үүсвэрийг арчлах хамгаалах арга хэмжээ авах	1-р багийн нутагт орших Номтын Сантын булагт амьтан ундаалдаг булаг усны эх үүсвэрийг хамгаалан хашаажуулан 3,9 сая төгрөгний зардал гарган арга хэмжээ авсан.
4	Биологийн төрөл зүйлийн ач холбогдол, хамгаалах чиглэлээр ажилчдад сургалт явуулах	Нийт ажиллагсадад Биологийн төрөл зүйлийн ач холбогдол, хамгаалах чиглэлээр сургалт 2 удаа явуулав. Энэ сургалтын хүрээнд Их захцага ууланд унасан модыг түүж ойн цэвэрлэгээ хийв.

Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний дагуу дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд дараах солбицол бүхий талбайнуудад техникийн нөхөн сэргээлт хийлээ

Цэгийн дугаар	Солбицол		Талбайн хэмжээ (га)
1	48° 17' 8.3''	104° 23' 11.7''	талбайн хэмжээ 1 га
2	48° 17' 4.4''	104° 23' 9.7''	
3	48° 17' 2.6''	104° 23' 14.00''	
4	48° 17' 7.6''	104° 23' 16.50''	



Зураг 25. Дүйцүүлэн хамгаалах чиглэлд орон нутгийн талбайд хийх координат



Зураг 25. Орон нутгийн талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн байдал



Зураг 27. Зөвшөөрөл авч ойд унаж өгөршсөн модыг түүж цэвэрлэв

Зураг 28. ан амьтан, байгаль хамгаалах сургалт хийж буй

Дүйцүүлсэн нөхөн сэргээлт хийсэн
талбай /2022он/-1.0га

1	454498.831	5348100.799	48 17 04.10266429	104 23 11.92957880
2	454499.884	5348205.691	48 17 07.50001131	104 23 11.93999657
3	454594.082	5348208.335	48 17 07.60999488	104 23 16.51000552
4	454593.572	5348101.471	48 17 04.14892180	104 23 16.52660114



2022 он
1.0 га

Таних тэмдэг



2022 онд техникийн нөхөн
сэргээлт хийсэн талбай



2022 онд биологийн нөхөн
сэргээлт хийсэн талбай



2022 онд дүйцүүлэн нөхөн
сэргээлт хийсэн талбай



Тусгай зөвшөөрлийн хил



Зураг 29. Дүйцүүлэн хамгаалах чиглэлээр Булган аймгийн Бүрэгхангай сумын 1-р багийн Номт- Сантын булгийг тохижуулав

5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тухайн төслийн уурхайлалтын болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төсөл хэрэгжих бүс нутаг, түүний орчимд хийсэн археологийн судалгаа, түүх соёлын өвийн судалгааны дүн, түүх, соёлын өв дурсгалуудын талаарх нутгийн иргэд, холбогдох байгууллагын мэдээлэлд үндэслэн түүх, соёлын өв дурсгалуудыг хамгаалах төлөвлөгөө боловсруулна.

Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг хүснэгтээр харуулав

ХОТУ ХХК-ны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан -2022 он

№	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Биелэлт
1	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгаж аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч гарын үсэг зуруулж ажилд гаргадаг.
2	Тунаах нуур, эргэлтийн усны даланг барилгын норм дүрмийн дагуу гүйцэтгэх	Тунаах нуур, эргэлтийн усны далангийн зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж барилгын норм дүрмийн дагуу гүйцэтгэсэн ба ба даланг тогмол өндөрлөх арга хэмжээ авдаг
3	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулсан
4	Гал унтраах хэрэгслээр бүрэн хангах арга хэмжээ авах,	Гал унтраах хэрэгслийг тогтмол шалгаж хугацаа дуусан хорыг дахин цэнэглэх эсвэл шинээр авч байна. Мөн бусад хэрэгслийн бүрэн бүтэн ажиллагаатай эсэхийг байнга шалгаж бүрэн байлган хангах арга хэмжээ авсан
5	Барилга байгууламжийг газар хөдлөлийн бүсэд тохируулан хийцийг сонгох	Барилга байгууламжийг газар хөдлөлийн бүсэд тохируулан хийцийг сонгосон
6	Осол эрсдэл үүссэн үед устгах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Осол эрсдэл үүссэн үед устгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан Налайхын уул уурхайн аврах ангиар батлуулан хэрэгжүүлж байна. Корона вирусын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан тусгаарлах байр, эм хангамжийн материал, ариутгал халдваргүйжүүлэлт, амны хаалт гар ариутгах хэрэгсэл , түргэвчилсэн оношлуур гэх мэтийг гамшгийн өндөржүүлсэн байдалд тохируулан зааврын дагуу тогтмол арга хэмжээ авч ажиллахаар бэлдсэн . Ажиллагсадаа эрүүл мэндийн үзлэгт хамруулсан. ОБЕГ-ийн харъяа Налайхын аврах ангиас бүрэн хэмжээний сургалт 2022 оны 4-р сард зохион байгуулсан
7	Ажилчдыг ажлын хувцас, хамгаалалтын тусгай хэрэгслээр (хөвөн даавуун материалаар хийсэн хувцас, резинэн хормогч, резинэн гутал, резинэн бээлий, резинэн хормогч, резинэн гутал, резинэн бээлий, хамгаалалтын нүдний шил, маск) хангах	Ажилчдыг ажлын хувцас, хамгаалалтын тусгай хэрэгслээр (хөвөн даавуун материалаар хийсэн хувцас, резинэн хормогч, резинэн гутал, резинэн бээлий, резинэн хормогч, резинэн гутал, резинэн бээлий, хамгаалалтын нүдний шил, маск) хангасан мөн корона вирусын үед гар ариутгах бодис амны хаалтыг тогтмол олгож байна.
8	Хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдлийг нарийвчлан мэргэжлийн байгууллагаар тогтоолгох	Хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдлийг нарийвчлан мэргэжлийн байгууллагаар тогтоолгуулсан



Зураг 26. Гал унтраах хэрэгсэл хангаж, аянга зайлуулагч суурилуулав



Зураг 31. Сургалт хийж буй байдал



Зураг 32. Хотхоноо газар хөдлөлийг тооцоолон байгуулсан




Зураг 33. Өдөр тутамын зааварчилгаа өгч халуун шалгаж буй нь




Зураг 34. Налайхы уул уурхайн аврах ангитай хамтран зохион байгуулсан сургалт



Зураг 35. Тусгаарлах байр.



Зураг 36. Амралтаараа явж ирээд тусгаарлалтанд байгаа ажиллагсадаас шинжилгээ авч сөрөг бол ажилд гаргадаг.



Зураг 37. Ээлж солилцох үед машинаа ариутган шилжүүлдэг.

8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Биелэлт
1	Ахуйн хаягдлыг ангилах дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулах, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээг авч байх	Ахуйн хаягдлыг ангилах дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулан Улаанбаатар хуванцар савыг тушаасан, бусад хог хаягдлыг түр хадгалах цэгт нэгдсэн цэгт байршуулан уурхайгаас 3 км-т байрлах Төв аймгийн Заамар сумын Шижир алт тосгоны хогийн нэндсэн цэгт асгаж байв. / Бүрэгхангай сумт 40 км хол зайтай тул Шижир алт суурингийн нэгдсэн цэгт зөвшөөрөл авч хаядаг./Зай хураагуур болон автомашины аккумуляторыг одоогоор авах газар нь үйл ажиллагаагаа түр зогсоосон тул хадгалж байна. Хог хаях зөвшөөрлийг хавсаргав.
2	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, ажилчдын байр, ШТС зэрэг газарт байрлуулах	Хогийн савыг өрөө бүрт байрлуулан гадаа ил задгай талбайд битүүмж сайтай тагтай хийх, ажилчдын байрны гадна, ШТС, уурхайн карьер зэрэг газарт байрлуулсан. Мөн тамхи татах цэг гаргаж зөвхөн тэнд тамхи татахаар зохион байгуулсан
3	Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан ялган цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан ялган цуглуулж дугуйг Улаанбаатар хот -д Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбооны дахин боловсруулах үйлдвэрт 800 л хаягдал тос масло нийлүүлсэн.

ХОТУ ХХК-ны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан -2022 он

№	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Биелэлт
4	Хаягдал ажилласан тосыг тусгай саванд цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт өгөх	Хаягдал ажилласан тосыг төрөл тус бүрээр тусгай саванд цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт Улаанбаатар хот СХД-д байршилтай Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбооны дахин боловсруулах үйлдвэрт 800 л хаягдал тос масло өгсөн. Тос тушаасан тодорхойлолт болон зургийг хавсаргав.
5	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөглөх	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулах, хог хаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хөтөлсөн. Сургалтын дараа нийтийн их цэвэрлэгээ хийж Мөн карьерийн хог хаягдал түүж цэвэрлэсэн. Мөн лицензийн талбай дотор цэвэрлэгээ хийхдээ үхрийн аргалыг ангилан түүж түлшиндээ хэрэглэсэн
6	Бие засах газар, бохирын худгийг MNS 5924: 2015 “Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага” стандартын дагуу барьж ашиглах	Бие засах газар, бохирын худгийг MNS 5924: 2015 “Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага” стандартын дагуу барьж ашигласан
7	Агаар бохирдуулах эх үүсвэр тутмын ялгарлыг бууруулах техник технологийн шийдлүүдийг төслийн эхэн үеэс эхлэн шийдвэрлэж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах	Агаар бохирдуулах эх үүсвэр тутмын ялгарлыг бууруулах зорилгоор автомашин техникийн сайн чанарын тос масло солих, сайн чанарын агаар шүүгчийг тогтсон мот цаг тутамд солих гм техник ашиглалтын арга хэмжээг тогтмол авч байна. Мөн хуулийн дагуу агаарын бохирдлын төлбөрийг хугацаанд нь төсөвт төлсөн.



Зураг 38. Ахуйг хог түр хадгалах цэгээс ачиж Шижир алтны хогийн цэгт тогмол асгадаг.



Зураг 39. Ашигласан тос масло УБ хот руу ачиж Монголын хог хаягдлын дахин боловсруулах үндэсний холбоонд тушаахаар ачиж буй байдал



Зураг 40. Тамхи татах цэг , нүхэн жорлон



Зураг 41. Их цэвэрлэгээний үеэр карьерийн хог түүв. Аргал ангилан түүж түлшиндээ хэрэглэв

9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор хийж гүйцэтгэсэн арга хэмжээнд хяналт хийх зорилгоор орчны хяналт шинжилгээг орон нутгийн байгууллага болон Булган аймгийн Ус цаг уур шинжилгээний газартай жил бүр гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Энэ хүрээнд 2022 онд 2 удаа 2022 оны 5-р сарын 21-ний өдөр , 2022 оны 9-р сарын 23-ны өдөр ирж дээж авч хяналт шинжилгээг авч хариуг ирүүлсэн. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авсны үр дүнд шинжилгээний хариу стандарт түвшинд хэвийн байна. Бүх шинжилгээний хариу , гэрээ , төлбөр төлсөн баримтыг хавсаргв.

№	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Биелэлт
1	Агаарын чанар	
